

Монгол улс

Агаарын бохирдлыг бууруулах газар (АББГ)

**Монгол улс Улаанбаатар хотын
Агаарын бохирдлын хяналтын чадавхыг
бэхжүүлэх төсөл
(2-р үе шат)**

**Техникийн хамтын ажиллагааны үр
дүнгийн тайлан 05**

**Агаар орчны хяналт шинжилгээний
нэгдсэн сүлжээ, олон нийтэд мэдээлэх
системийн гарын авлага**

2017 он 5 сар

**Японы Олон Улсын Хамтын
Ажиллагааны байгууллага (ЖАЙКА)**

Сүүрикэйкакү ХК

Өмнөх үг

Монгол улс нь 1977 онд анх удаа агаар орчны хэмжилт хийж эхэлсэн боловч бүрэн автоматаар хийж эхэлсэн нь 1998 онд зүүн ази бүс нутгын хүчиллэг борооны хяналт шинжилгээний сүлжээ (EANET)-нь анхдагч юм. Түүний дараагаас 2009 онд Герман улсаас буцалтгүй тусламжын хүрээнд НАЧА 4 газар агаар орчны суурин харуул суурилуулан хэмжиж эхэлсэн. 2010 онд Франц улсын хөнгөлттэй зээлийн хүрээнд ЦУОШГ –г агаар орчны суурин харуулыг 5 газар суурилуулан хэмжиж эхэлсэн.

Тус техникийн хамтын ажиллагааны төслийн хүрээнд ЖАЙКА болон Улаанбаатар хотын хүрээнд хамтран хэлэлцэн 2013 оны зуны байдлаар хэмжилтын дата утгыг тус тусдаа хадгалах болсон. Нийслэлийн иргэд уруу чиглэсэн нийтэд мэдээлэх ажлын хувьд 1 өдрөөс илүү хугацаа шаарлагатай зэрэг асуудал байсан. Энэ хүү асуудлыг шийдвэрлэхийн тулд доорх ажлууд төлөвлөгдөн хийгдсэн.

- 1) НАЧА, ЦУОШГ-ын агаар орчны мониторингийн нэгдсэн сүлжээг бий болгох (Y/A 2-4)
- 2) Мониторингийн сүлжээний талаар шаардлагатай гарын авлагыг боловсруулах. (Y/A 2-6)
- 3) Агаар орчны мониторингийн сүлжээг ажиллуулж, агаар орчны мэдээллийг нийтэд мэдээлэх, сэрэмжлүүлэг зарлах. (Y/A 5-1)

Энэ хүү гарын авлаг нь Y/A 2-6-ын үр дүн болно. Бэлтгэх явцад доорх чиглэлийг баримтласан.

- 1) Тоног төхөөрөмж бүрт гарын авлага хийгдсэн байгаа.
- 2) Агаарын чанарын ухаалаг хяналтын системн тухайд энэ хүү системн зохион бүтээсэн ASTVISION компаниас гарын авлагыг бэлтгэн захиалагч тал болох Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороонд гардуулан өгсөн. Одоогын байдлаар тус хорооны үйл ажиллагааг үргэлжүүлж байгаа БОАЖЯ-ны орчны агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрын ажлын хэсэгт шилжсэн.
- 3) Дээрх 2 материалд дутуу хэсгийг JICA мэргэжилтнн баг , АББГ, ЦУОШГ, БОХЗТЛ-ын хариуцсан мэргэжилтнүүд бэлтгэн гаргана. Тэдгээрийг нийлүүлэн 「Агаар орчны хэмжил зүйн төв сүлжээ, нийтэд мэдээлэх систем」 -ын гарын авлага болгоно.

Мөн энэ хүү гарын авлагад хэрэглэгчийн нэр нууц үг, программын мэдээлэл, IP хаяг зэрэг нууц мэдээлэл агуулагдаж байгаа улмаас хамааралтай хүмүүсээс бусал хүмүүст мэдээллэхгүй байх шаардлагатай. Үүний улмаас нийтэд мэдээллэгдэх материалаас тус бүлгийг хассан байгаа.

АББГ-с техникийн хамтын ажиллагааны төсөлийн хэрэгжих хугацаанд оролцсон боловч хариуцсан Зажилтан хасагдсан байсан. ЦУОШГ болон БОХЗТЛ-ын 2ажилтан хамрагдсан. Энэ хэвээр бол зуны амралт болон урт хугацааны гадаад томилолт, халагдах, амралт авах зэрэг асуудал

гарсан үед үргэлжлүүлэх мэргэжилтэн байхгүй болно. АББГ ,ЦУОШГ болон БОХЗТЛ энэ хүү гарын авлагыг ашиглан орлох хүнийг бэлтгэх ажлыг чин сэтгэлийн угаас хүсч байна.




2017 оны 5 сар

Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах

хяналтын чадавхыг бэхжүүлэх төсөл 2-р үе шат

ЖАЙКА мэргэжилтэний баг

Зураг



Монгол улс Улаанбаатар хотын Агаарын бохирдлын хяналтын чадавхыг бэхжүүлэх төсөл (2-р үе шат)

Техникийн хамтын ажиллагааны үр дүнгийн тайлан 05

Агаар орчны хяналт шинжилгээний нэгдсэн сүлжээ, олон нийтэд мэдээлэх системийн гарын авлага

Гарчиг

АББГ


1) Хяналтын систем

AQMA серверын тохиргоо	1-1-1
IDAZRW болон DCS-ын тохиргоо/ашиглалт.....	1-2-1
Өвлийн цагийн өөрчлөлттэй холбогдуулан суурин харуулын цагийн тохиргоог солих тухай ...	1-3-1
Хэмжилтийн төхөөрөмжөөс I/O expander уруу дата дамжуулах	1-4-1
Суурин харуулаас шинэ мэдээ авах боломжгүй болсн тохиолдолд	1-5-1

2) Суурин харуулд

Хэмжилтийн багаж түүний алдааны код.....	2-1-1
Суурин харуулын модемын тохиргоо	2-2-1
I/O Expander-ын температур хэмжигч	2-3-1
IO Expander-ын өрөөний температур болон чийгшил хэмжигчийн суурилуулах арга.....	2-4-1
Хэмжилтийн бага тус бүрийн зөвшөөрөгдсөн тасалгааны температур болон чийгшил	2-5-1

3) <http://www.air.ub.gov.mn/>

http://www.air.ub.gov.mn/ -ын backup	3-1-1
Web Site Domain  Hosting Server-ын шинэчлэх ажил	3-2-1
http://www.air.ub.gov.mn/ -ын restore.....	3-3-1
http://www.air.ub.gov.mn/ -ын систем шинэчлэл	3-4-1
Mailing List хүмүүсийн шинэчлэлт	3-5-1
АББГ-ын суурин харуулын 30 минутын дундаж хэмжилтийн утгыг гаргах аргачлал	3-6-1

4) Мэдээлэл дамжуулах систем

Сургуульд суурилуулсан LCD дэлгэцний тохиргоо гарын авлага.....	4-1-1
---	-------

ЦУОШГ/БОХЗТЛ

2) Суурин харуулд

Мэдээ тасалдхаас сэргийлсэн тохиргоо.....	2-1-1
4G-г ашиглах суурин харуулын тохиргоо	2-2-1

4) Мэдээлэл дамжуулах систем

БОАЖЯ болон ЦУОШГ-ын LCD компьютерын тохиргоо	4-1-1
---	-------

Монгол улс Улаанбаатар хотын Агаарын бохирдлын хяналтын чадавхыг бэхжүүлэх төсөл (2-р үе шат)

Техникийн хамтын ажиллагааны үр дүнгийн тайлан 05

Агаар орчны хяналт шинжилгээний нэгдсэн сүлжээ, олон нийтэд мэдээлэх системийн гарын авлага

Гарын авлагын гол агуулгын тухай

Өмнөх үгт тайлбарласны дагуу гарын авлагад хэрэглэгчийн нэр, нууц үг, программ хангамжийн хувилбар, IP хаяг гэх мэт нууцлах шаардлагатай их хэмжээний мэдээллүүд агуулагдаж байгаа. Тиймээс тус гарын авлагын гол агуулгыг олон нийтэд зориулсан хувилбарт оруулаагүй болно.

Улмаар энэхүү гарын авлагыг ашиглах Монгол тал болон тус төслийн үр дүнг шалгах ЖАЙКА-ийн хариуцсан салбарт гаргасан хувилбарт гарын авлагын гол агуулгыг нэмэлтээр оруулсан.

Монгол улс

Агаарын бохирдлыг бууруулах газар (АББГ)

**Монгол улс Улаанбаатар хотын
Агаарын бохирдлын хяналтын чадавхыг
бэхжүүлэх төсөл
(2-р үе шат)**

**Техник Хамтын Ажиллагааны хүрээнд
боловсруулсан баримт бичиг 06
PM10 болон PM2.5-ын хэмжилт, дүн
шинжилгээний гарын авлага**

2016 оны 9 дүгээр сар

**Японы Олон Улсын Хамтын
Ажиллагааны байгууллага (ЖАЙКА)**

Сүүрикэйкакү ХК

Өмнөх үг

Төслийн хүрээнд 2014 оноос 2016 он хүртлэх 3 жилийн хугацаанд нийслэлийн хэд хэдэн байршилд, улирал бүрээр агаар дахь PM10 болон PM2.5-ын нийт 120 дээж авч, элементийн найрлагын шинжилгээ хийхээр төлөвлөсөн. Сорьц авах байршлын хувьд тог цахилгааны найдвартай байдал болон аюулгүй байдлыг харгалзан үзэж нийслэл дэх 10 суурин харуулын байршилд (УБ 6 харуул, НАЧА 4 харуул) тулгуурлан дээж авсан. Мөн 2014 оны өвлийн улиралд Чингэлтэй дүү рэгт айлын хашаанд авсан.

PM10 болон PM2.5-ын сорьцыг авч фильтрийн жингийн аргаар тэдгээрийн агууламжийг тодорхойлсон. PM2.5-ийн химийн найрлагад төрөл бүрийн элементүүд, нүүрс төрөгчийн нэгдэл, уусамтгай ион голлодог. Монголд элементийн дүн шинжилгээний нарийн багаж төхөөрөмж байдаггүй тул дээрх сорьцийг Японд PM-ийн элементийн найрлагын шинжилгээ хийж гүйцэтгэсэн.

PM2.5 болон PM10-ын агууламжийн дүн шинжилгээтэй холбоотой ажлын дарааллыг гарын авлагад нэгтгэн оруулсан. Мөн PM-ын элементийн дүн шинжилгээ хийх аргачлалыг энэхүү гарын авлагад тусгаж оруулсан.

Техник хамтын ажиллагааны төсөл хэрэгжих хугацаанд хэд хэдэн ажилчдыг сургалтад хамруулж ирсэн боловч тухайн ажилчны нөхцөл байдлаас шалтгаалан ажлаасаа гарах, урт хугацааны чөлөө авах тохиолдолд гардаг. PM2.5 болон PM10-ын агууламж хэмжилтийн ажлыг тасралтгүй, үнэн зөв хийж гүйцэтгэхийн тулд АББГ, ЦУОШГ болон БОХЗТЛ нь энэхүү гарын авлагыг ашиглан өөрсдийн залгамж үеийг бүрэн дүүрэн бэлтгэн гаргахыг чин сэтгэлээсээ хүсч байна.

2016 оны 9 дүгээр сар


Улаанбаатар хотын агаарын бохирдлын хяналтын чадавхыг бэхжүүлэх төсөл 2 дугаар үе шат

ЖАЙКА мэргэжилтний баг

Зураг



Thermo FRM 2000i дээжлэгч



MCAS Slit Jet Sampler багаж



Thermo FRM2000i дээжлэгч



MCAS Slit Jet Sampler багаж



Thermo FRM2000i дээжлэгч



Фильтр жинлэлт

Гарчиг

Фильтр жинлэх аргачлал	1-1
Орчны төлөв тогтворжуулагчыг ашиглах	2-1
Slit Jet Sampler багажны фильтр солих ажлын дараалал.....	3-1
Slit Jet Sampler багажинд фильтр суурилуулан ажилуулах гарын авлага	4-1
FRM2000i-ийн ажиллагааны гарын авлага	5-1
PM-ийн элеменетийн дүн шинжилгээ.....	6-1

1 Фильтр жинлэх аргачлал

METTLER TOLEDO XP6



1 . Фильтр жинлэх ажлын дараалал

- ① Фильтрийг Climate Chamber-т хийнэ.
- ② $21.5^{\circ}\text{C}\pm 1.5^{\circ}\text{C}$, $35\%\pm 5\%$ орчинд фильтрийг 1 өдөр хадгална.
- ③ Өндөр нарийвчлалын электрон жинг хүчдэлд залгана.
- ④ Электрон жингийн “0” тохиргоог хийнэ.
- ⑤ Электрон жингийн хаалгыг нээж фильтрийг хэмжүүрийн төв хэсэгт байрлуулж жингийн хаалгыг хаана. Энэ үед ямар нэгэн чичиргээ үзүүлэхгүй байхаар үйлдлийг нэг гараараа хийж гүйцэтгэнэ.
- ⑥ Хэмжилтийн утга тогтворжих үед үр дүнг бичиж тэмдэглэнэ.
- ⑦ Электрон жингийн хаалгыг нээж, фильтрийг гарган зориулалтын хайрцагт хадгална.

Анхаарах зүйлс

- Фильтрийг аль болох нэг хүнээр дагнан жинлүүлж байх. Хүн тус бүрийн хэмжилт өөр өөр байдаг.
- Электрон жингийн хэмжилтийн үзүүлэлтийг тогтворжуулахын тулд нэг гараараа жинлэх үйлдлийг гүйцэтгэж хэмжүүрийн эргэн тойронд илүү хөдөлгөөн хийхээс зайлсхийх.
- PTFE фильтр : Төмөр хавчигчаар цагирагны хэсгээс барих. Нүх гаргалгүй анхааралтай суурилуулах.
- QUARTZ фильтр: Фильтрийг суурьнаас хөндийрүүлэн төмөр хавчигч ашиглан салгаж авах.

2 . Электрон жинд үүссэн асуудал болон засвар үйлчилгээ

Электрон жинд үүссэн асуудлыг шийдвэрлэх, засвар үйлчилгээ хийхтэй холбоотой мэдээллийг багажны техникийн гарын авлагаас харна уу.

3 . Бусад

Электрон жингийн ажиллагааны талаарх илүү дэлгэрэнгүй мэдээллийг тус багажны техникийн гарын авлагаас харна уу.

2 F C C Z багажны ажиллагааны дараалал



- 1 Багажны үндсэн хүчдэлийг залгана.
- 2 Нөөцийн усны савны хэмжээг шалгана.
- 3 Илүүдэл усны савыг бүрэн суллана. (Өдөрт 1 удаа тогтмол шалгаж, усны сав дүүрч халихаас сэргийлэх.)
- 4 Төхөөрөмжийн тохируулга 21.5°C35% байгаа эсэхийг шалгах.
- 5 Багажны (RUN • STOP) товчлуурыг дарна.
- 6 2 цагийн дараа дээрх температур, чийгшлийн үзүүлэлтүүд тогтворжсон эсэхийг шалгана.
- 7 Тохируулгын үзүүлэлт тогтворжих хугацаанд C640 C641 C140 кодын алдаанууд түр гарч, үзүүлэлт тогтворжих үед арилна.
※Дээрх алдааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг англи хэл дээрх гарын авлагаас харна уу.
- 8 Багажны ажиллагааг зогсоохдоо 5-ийн STOP товчлуурыг дарна.
- 9 Багажыг ажиллагаа зогссоны дараа COOL гэсэн бичиглэл гарна.
- 1 0 Ойролцоогоор 30 минутын дараа багажны ажиллагаа бүрэн зогсоно.

Анхаарах зүйлс:

- Багажыг ажиллуулах явцад чамберийн дотор чийгшил өсдөг тул хэдэн минутын турш чамберийн хаалгыг нээж байх.
- Багажыг зогсоосны дараа шууд RUN товчлуурыг дарахад чийгшил өсдөг тул чамберийн хаалгыг нээж чийгшилийг гадагшуулах шаардлагатай.
- HEPA-ийн фильтр болон савны нарийн ширхэглэлт тоосонцор шүүгч бөглөрсөн тохиолдолд температур болон чийгшлийн тохируулгын үзүүлэлт тогтворжихгүй болдог. Иймээс жилд 1 удаа үзлэг үйлчилгээ хийх шаардлагатай.

3 Дээжлэгчийн фильтрийг солих ажлын дараалал

Нийтлэг зүйлс

Дээжлэгчийн эх биеэс импакторыг салгана. Цэвэр салфитик доор нь дэвсээнэ.



Коарц фильтр

Цэвэрлэгээний спирт болон салфиткаар төмөр хавчаарыг арчиж цэвэрлээнэ.



Түгжээг мулталж ① болон ②-ийг салгана.



3 Дээжлэгчийн фильтрийг солих ажлын дараалал

③Моторын суурь хэсгээс импакторын фильтрийн үүрийг салгана.



Фильтрийн үүр болон жийргэвч резинийг салгана.



Фильтрийг төмөр хавчаар ашиглан хадгалах хайрцагт хийнэ.



Хайрцагны тагийг таглаж, лентээр орооно.



3 Дээжлэгчийн фильтрийг солих ажлын дараалал

Цэвэр салфитикаар импакторын үүрийг арчиж цэвэрлэнэ.



Цэвэр салфитикаар импакторын үүрийг арчиж цэвэрлэнэ.



Цэвэр салфитикаар импакторын үүрийг жийгэвчийг арчиж цэвэрлэнэ.



③ болон ④-ийг салгана.



3 Дээжлэгчийн фильтрийг солих ажлын дараалал

BACK UP фильтрийн үүрийг салгана



BACK UP фильтрийн үүрний дээд хэсгийг салгана.



BACK UP фильтрийн үүрний дээд хэсгийг салгахдаа хавтгай төмөр хавчаар ашиглахыг зөвлөж байна.

Фильтрийг төмөр хавчаараар салгаж зөөнө.



Фильтрийн доор байрлах сеткан суурийг төмөр хавчаараар салгана.

Хайрцагны таглааг таглаж, лентээр орооно.



3 Дээжлэгчийн фильтрийг солих ажлын дараалал

Цэвэр салфитикаар BACKUP фильтрийн суурийг цэвэрлэнэ.



Цэвэр салфитикаар BACKUP сеткан суурийг арчиж цэвэрлэнэ.



BACK UP фильтрийн үүрэнд шинээр 2 фильтрийг суурилуулна.



Импактор фильтрийн үүрэнд 1 ш шинэ фильтрийг суурилуулна.



3 ДЭЭЖЛЭГЧИЙН ФИЛЬТРИЙГ СОЛИХ АЖЛЫН ДАРААЛАЛ

BACK UP фильтрийн үүрэнд суурилуулсан фильтр голлож байхаар тохируулна.



BACKUP фильтрийн дээрээс таглаж сайтар чангална.



Шинэ BACKUP филтэртэй үүрийг BACKUP сууринд (⑤) суурилуулна.



Суурилуулахын өмнө улаан өнгийн жийргэвчийг ховилд суулгана.

③ болон ④-ийг өмнөх байрлалд буцаана.



④ болон ⑤-ын хооронд зай завсар гарахаас сэргийлнэ.

3 Дээжлэгчийн фильтрийг солих ажлын дараалал

Импактор үүрэнд суурилуулсан филь-
тр голлож байхаар тохируулна.



Фильтрийн дээрх жийргэвчийг суурил-
уулна.



Жийргэвч фильтрийн хооронд зай га-
рахаас сэргийлнэ.



Импактор фильтрийн суурийг сайтар
чангална.



Шинэ фильтр суурилуулсан суурийг
моторын сууринд (③) угсарна.

Моторын суурь (③) -т улаан өнгийн
жийргэвчийг зөв суурилуулсан эсэхи
йг нягтална.

3 Дээжлэгчийн фильтрийг солих ажлын дараалал

① болон ②-ыг буцааж угсрахын өмнө цэвэрлэнэ.
Түгжээг мулталж ①-ийг ②-оос салгана.



Салфитикаар ①-ийг арчина.



Салфитикаар ②-ийн дээд хэсгийг арчиж цэвэрлэнэ.



Салфитикаар ②-ийн доод хэсгийг арчиж цэвэрлэнэ.



3 Дээжлэгчийн фильтрийг солих ажлын дараалал

①-ийг ②-т угсарч түгжээг чангална.



① болон ②-ийг моторын сууринд суурилуулж (③) түгжээг чангална.



PTFE фильтр

Цэвэрлэгээний спирт болон салфиткаар төмөр хавчаарыг арчиж цэвэрлэнэ.



Түгжээг мулталж ① болон ②-ийг салгана.



③Моторын суурь хэсгээс импакторын фильтрийн үүрийг салгана.



3 Дээжлэгчийн фильтрийг солих ажлын дараалал

Фильтрийн үүр болон жийргэвч рези нийг салгана.



Фильтрийг төмөр хавчаар ашиглан х адгалах хайрцагт хийнэ.



Хайрцагны тагийг таглаж, лентээр о рооно.



Цэвэр салфитикаар импакторын үүр ийг арчиж цэвэрлэнэ.



3 Дээжлэгчийн фильтрийг солих ажлын дараалал

Цэвэр салфитикаар импакторын үүр болон жийргэвч резинийг арчиж цэвэрлэнэ.



Цэвэр салфитикаар сеткан суурийг арчиж цэвэрлэнэ.



③ болон ④-ийг салгана.



BACK UP фильтрийн үүрийг салгана



3 ДЭЭЖЛЭГЧИЙН ФИЛЬТРИЙГ СОЛИХ АЖЛЫН ДАРААЛАЛ

BACK UP фильтрийн үүрний дээд хэсгийг салгана.



BACK UP фильтрийн үүрний дээд хэсгийг салгахдаа хавтгай төмөр хавчаар ашиглахыг зөвлөж байна.

Фильтрийг төмөр хавчаараар салгаж зөөнө.



Фильтрийн доор байрлах сеткан суурийг төмөр хавчаараар салгана.



Хайрцагны таглааг таглаж, лентээр орооно.



Цэвэр салфитикаар BACKUP фильтрийн суурийг цэвэрлэнэ.

3 Дээжлэгчийн фильтрийг солих ажлын дараалал

Цэвэр салфитикаар BACKUP сеткан суурийг арчиж цэвэрлэнэ.



BACK UP фильтрийн үүрэнд фильтр ийг суурилуулна.



BACK UP фильтрийн үүрэнд фильтр ийг суурилуулж чангална



Шинэ BACKUP филтэртэй үүрийг BACKUP сууринд (⑤) суурилуулна.



Суурилуулахын өмнө улаан өнгийн жийгэвчийг ховилд суулгана.

3 Дээжлэгчийн фильтрийг солих ажлын дараалал

③ болон ④-ийг өмнөх байрлалд буцаана.

④ болон ⑤-ын хооронд зай завсар гарахаас сэргийлнэ.

Импактор үүрэнд фильтрийг суурилуулна.

Фильтрийн дээрх жийргэвчийг суурилуулна.

импакторын таглааг угсарна. Шинэ фильтртэй үүрийг моторын сууринд бэхэлнэ. (③)

Моторын суурь (③) -т улаан өнгийн жийргэвчийг зөв суурилуулсан эсэхийг нягтална.



3 Дээжлэгчийн фильтрийг солих ажлын дараалал

① болон ②-ыг буцааж угсрахын өмнө цэвэрлэнэ.
Түгжээг мулталж ①-ийг ②-оос салгана.



Салфитикаар ①-ийг арчина.



Салфитикаар ②-ийн дээд хэсгийг арчиж цэвэрлэнэ.



Салфитикаар ②-ийн доод хэсгийг арчиж цэвэрлэнэ.



3 Дээжлэгчийн фильтрийг солих ажлын дараалал

①-ийг ②-т угсарч түгжээг чангална.



① болон ②-ийг моторын сууринд суурилуулж (③) түгжээг чангална.



Нийтлэг зүйлс

Дээжний фильтрийг бохирдохоос хамгаалж зориулалтын саванд хадгална.



Хөнгөн цагаан цаасанд ороож хөргөгчинд хадгална.



4 SLIT JET AIR SAMPLER

(Тоосонцрын багажны техникийн гарын авлага)

Марк MCAS-SJ-M4-S1

Энэхүү гарын авлага нь Мурата ХК-ны Slit Jet Sampler багаж (MCAS SJ-M4-S1)-ны гарын авлагыг Монгол хэлэнд орчуулан гаргасан материал бөгөөд Япон мэргэжилтэн нь Х/Т-ын сургалтын материал болгон ашигласан. Х/Т нь шаардлагатай тохиолдолд энэхүү гарын авлагыг ашиглаж байна. Slit Jet Sampler (MCAS SJ-M4-S1)-ын зохиогчийн эрхийг Мурата ХК эзэмшдэг.

5 Орчны агаараас сорьц авагч багаж (FRM)

Техникийн гарын авлага

Марк: 2000i

Энэхүү гарын авлага нь Thermo Scientific ХК-ны орчны агаараас сорьц авагч (FRM) Model2000i багажны товч гарын авлагыг Монгол хэлэнд орчуулан гаргасан материал бөгөөд Япон мэргэжилтэн нь Х/Т-ын сургалтын материал болгон ашигласан. Х/Т нь шаардлагатай тохиолдолд энэхүү гарын авлагыг ашиглаж байна. Thermo Scientific орчны агаараас сорьц авагч (FRM) Model2000i багажны товч гарын авлагын зохиогчийн эрхийг Thermo Scientific ХК эзэмшдэг.

6. РМ-ийн элементийн найрлагын дүн шинжилгээний гарын авлага


PM-ийн элементийн найрлагын дүн шинжилгээ

Тоосонцрын /PM/ химийн найрлагад төрөл бүрийн элементүүд, нүүрс төрөгчийн нэгдлүүд болон уусамтгай ион голлон агуулагддаг.

1. Элементийн шинжилгээ

Тефлон фильтрийг жинлэсний дараагаар энергийн ялгалтай спектрометр (ED-XRF) багажаар гол төрлийн элементүүдийн (Na, Mg, Al, Si, P, S, Cl, K, Ca, Ti, V, Cr, Mn, Fe, Ni, Cu, Zn, As, Se, Br, Rb, Sr, Mo, Sn, Sb, Ba, Pb) агууламжийг тодорхойлсон.

Сонгосон элементэд рентген тусгаж үүссэн рентген флуоресценцийн спектрыг хагас дамжуулагч детектор ашиглан хэмжинэ Спектрт хэмжигдсэн пийкийн энергээс элементийг тодорхойлж тэрхүү пийкийн чадлыг элементийн агууламжийг ($\mu\text{g}/\text{cm}^2$) урьдчилан бэлдсэн референс материалын чадалтай харьцуулна. Тефлон фильтрийг жинлэсний дараагаар энергийн ялгалтай спектрометр (ED-XRF) багажаар дүн шинжилгээнд хамруулах элементээс хамаарч тохирох хоёрдогч таргетийг ашиглан рентген туяагаар шарна. Хамгийн багадаа 7 төрөл (Al, CaF₂, Fe, Ge, Mo, Al₂O₃, CeO₂) ийн хоёрдогч таргет бодис ашиглан хэмжиж рентген флуоресценцийн спектрт дүн шинжилгээ хийж бүх төрлийн элементүүдийн агууламжийг тодорхойлно. Хоёрдогч таргет бодисоор Мо-г сонгон шарж, Ge хагас дамжуулагч детектороор хэмжсэн рентген флуоресценцийн спектрыг Зураг 1-т жишээгээр үзүүлэв.



Зураг 1. PM2.5-ийн сорьцны рентген флуоресценцийн спектр (Хоёрдогч таргет Мо)

2. Нүүрс төрөгчийн нэгдэл


Нүүрстөрөгчийн нэгдлүүдийг PM-ийн дээжнээс (8mmφ)-гэйг нь сонгож DRI Model 2001 дулаан, гэрлийн ОС/ЕС нүүрстөрөгчийн анализатор ашиглан IMPROVE-A хэмжил зүйн аргачлалаар органик нүүрстөрөгч ОС, элементийн нүүрстөрөгч ЕС-ийг ангилан тодорхойлсон. Энэхүү аргачлалаар органик нүүрстөрөгч ОС –г 4 фракцаар (ОС1~ОС4) , элементийн нүүрстөрөгч ЕС-ийг 3 фракц (ЕС1~ЕС3)-д ангилан нүүрстөрөгчийн хэмжээг тодорхойлж Не-ийн орчин дахь ОС-ийн тортогжилтийн хэмжээг (ОСруго) дээжний гадаргуу дээрх тортогжилтийн өөрчлөлтөөр тохируулсан. Фракц тус бүрийн шинжилгээний орчин болон температурын хамаарлыг Хүснэгт 1-г, Фракцаас хамаарах нүүрс төрөгчийн нэгдлийн тодорхойлолтыг Хүснэгт 2-т нэгтгэв. Сорьцны термограммыг Зураг 2-г жишээгээр харуулав.

Хүснэгт 1. Фракц болон лабораторын орчин, температурын хамаарал

Measurement Condition			
Carbon fraction	Sensor setting temperature		Analysis-atmosphere
	IMPROVE	IMPROVE-A	
OC1	120°C	140°C	He
OC2	240°C	280°C	He
OC3	450°C	480°C	He
OC4	550°C	580°C	He
EC1	550°C	580°C	98%He+2%O ₂
EC2	700°C	740°C	98%He+2%O ₂
EC3	800°C	840°C	98%He+2%O ₂

Хүснэгт 2. Фракц бүрээр нүүрстөрөгчийн нэгдлүүдийг тодорхойлох

Total C : TC = OC1 + OC2 + OC3 + OC4 + EC1 + EC2 + EC3
Organic C : OC = OC1 + OC2 + OC3 + OC4 + OC _{pyro}
Elemental C : EC = TC - OC
Volatile OC : VOC = OC1
High Temperature OC : HTOC = OC - OC1
High Temperature EC : HTEC = EC2 + EC3 - max(OC _{pyro} - EC1)



Зураг 2. Сорьцны термограмм

3. Уусамтгай ион

Уусамтгай ионы дүн шинжилгээг коарц филтэрт шүүгдсэн РМ-ийн дээжний тал хувийг нь ионгүйжүүлсэн 10 ml нэрмэл усанд хэт авианы долгион нэвтрүүлж, ионхроматографийн аргачлалаар (CO_3^{2-} , Cl^- , NO_3^- , SO_4^{2-}) болон (Na^+ , NH_4^+ , K^+ , Ca^{2+}) агууламжийг тодорхойлсон.

4. Элементийн найрлагын дүн шинжилгээний үр дүн

PM2.5-ийн химийн найрлагад төрөл бүрийн элементүүд, нүүрс төрөгчийн нэгдэл, уусамтгай ион голлодог. Рентген флуоресценцийн спектр ашиглан хийсэн шинжилгээний дүн буюу PM2.5 дахь элементийн агууламж, нүүрс төрөгчийн нэгдлийн агууламж болон ионы агууламж зэргийг Хүснэгт 3-аас Хүснэгт 5-д нэгтгэв. Сорьцны нэр (Sample) гэдэгт дээж авсан Улаанбаатар хотыг (UB)-ээр, ОГНОО (ууууммdd), Байршил нь БОХЗТЛ буюу CLEM (C), НАЧА буюу AQDCC (A), PM2.5 (F), PM10 (L) гэсэн дарааллаар илэрхийлсэн.

Хүснэгт 3. Рентген флуоресценцийн спектрометр ашиглан хийсэн PM2.5 дахь химийн элементүүдийн анализ (2014 оны 1-р сарын сорьц)

Sample	(unit: $\mu\text{g}/\text{m}^3$)									
	20140117-UB05		20140118-UB05		20140120-UB07		20140121-UB07		20140123-UB02	
Na	1.6	18	0.25	9	0.19	17	0.14	24	0.34	11
Mg	0.9	***	0.09	***	0.10	***	0.09	***	0.12	***
Al	0.4	***	0.07	***	0.05	***	0.14	***	0.07	***
Si	0.4	***	0.5	38	0.4	41	0.52	30	0.91	25
P	0.4	***	0.04	***	0.05	***	0.04	***	0.04	***
S	49	4	4.1	6	7.8	5	4.4	5	4.4	4
Cl	8.8	7	1.6	8	0.81	15	0.88	11	1.14	7
K	0.89	3	0.17	3	0.20	3	0.16	5	0.27	24
Ca	0.49	3	0.33	2	0.31	2	0.43	3	0.64	14
Ti	0.085	9	0.021	7	0.023	8	0.017	17	0.05	48
V	0.01	***	0.003	29	0.003	34	0.001	***	0.006	***
Cr	0.01	***	0.001	***	0.001	***	0.002	***	0.005	***
Mn	0.1	***	0.015	9	0.02	42	0.02	44	0.023	8
Fe	0.56	26	0.22	2	0.34	10	0.40	11	0.66	1
Ni	0.01	***	0.001	***	0.001	***	0.001	***	0.001	***
Cu	0.1	***	0.015	4	0.010	***	0.02	***	0.016	7
Zn	0.50	24	0.063	2	0.079	16	0.069	22	0.082	2
As	0.099	11	0.021	6	0.019	12	0.010	11	0.015	9
Se	0.32	9	0.026	10	0.024	19	0.023	17	0.036	9
Br	0.091	16	0.016	9	0.011	19	0.010	21	0.014	13
Rb	0.02	***	0.002	***	0.002	***	0.002	***	0.002	***
Sr	0.02	***	0.002	***	0.003	18	0.002	***	0.013	10
Mo	0.10	***	0.008	***	0.008	***	0.008	***	0.012	***
Sn	0.09	***	0.008	***	0.007	***	0.007	***	0.010	***
Sb	0.09	***	0.009	***	0.008	***	0.008	***	0.010	***
Ba	0.3	***	0.02	***	0.02	***	0.02	***	0.03	***
Pb	0.17	27	0.049	10	0.035	25	0.057	16	0.030	19

*** нь детекторын лимитээс бага, нийт утгын зөрүүг хувиар

* дээжний зузааныг засварлаагүй, бланкыг засварлаагүй

Хүснэгт 4. (IMPROVE-A) аргачлалд тулгуурлан хийсэн нүүрс төрөгчийн нэгдлийн шинжилгээний дүн (2014 оны 1 сард авсан дээж)

(unit: $\mu\text{g}/\text{m}^3$)

Sample	Reg. OC	VOC	HighT. OC	Reg. EC	High T. EC	TC	Спыг-Р
UB20140117C5F	175	72	103	28	0.5	203	44
UB20140118C5F	59	23	36	12	0.8	71	16
UB20140120C7F	63	20	43	12	1.2	76	22
UB20140121C7F	33	8	25	10	1.0	43	10
UB20140123C2F	96	45	51	18	0.9	114	23
Grand av.(%)	83	31	52	17	1	100	23

Хүснэгт 5. Ионхроматографаар тодорхойлсон уусамтгай ионы шинжилгээний дүн (2014 оны 1 сард авсан дээж)

($\mu\text{g}/\text{m}^3$)

Sample Ion	UB20140117C5F	UB20140118C5F	UB20140120C7F	UB20140121C7F	UB20140123C2F
CO_3^{2-}	1.1	-	-	1.3	-
C^{-}	5.3	2.9	0.9	1.0	2.4
NO_3^{-}	8.4	3.4	6.8	5.4	3.7
SO_4^{2-}	23.2	9.1	15.3	8.0	12.2
Na^{+}	0.4	0.1	< 0.1	0.1	0.1
NH_4^{+}	18.1	6.8	9.8	5.7	9.3
K^{+}	0.3	0.5	0.1	< 0.1	0.4
Ca^{2+}	1.1	< 0.1	0.3	0.3	< 0.1

5. Голлох эх үүсвэрийн ангилалд хийсэн анализ


Нарийн ширхэглэлт тоосонцор PM2.5-ийн массийн агууламжийг түүний химийн найрлагын агууламжаас тооцож гаргасан гол эх үүсвэрийн ангилал, нөлөөллийн агууламжийн нийлбэр буюу өөрөөр хэлбэл нэгтгэсэн жингийн массийн (RCFM) агууламжаар илэрхийлэх боломжтой. Улмаар фильтрийн аргачлалаар тодорхойлогдох PM2.5-ийн массийн агууламж болон RCFM агууламжийн харьцуулалтаар фильтрийн массийн агууламж болон химийн элементийн дүн шинжилгээний үр дүнгүүд зөрчилтэй эсэхийг шалгаж үзэх боломжтой.

Хэмжилтийн дүнг PM2.5-ийн агууламж болон найрлагын дүн шинжилгээний үр дүнгээс тооцож гаргасан RCFM агууламжтай харьцуулсан дүнг Зураг 3 ~ Зураг 7-д харуулав. Аль ч үр дүнгээс харахад PM2.5-ийн агууламжийн 80 гаруй хувийг RCFM-ийн агууламжаар тайлбарлаж болохоор байна.


Гол эх үүсвэрийн найрлагад тоосонцор хэлбэрийн органик нэгдлүүд (POM) нь 60%, үүний дараагаар $(\text{NH}_4)_2\text{SO}_4$ (10%), EC (8%), NH_4NO_3 (4%), хөрснөөс үүдэлтэй тоосонцор (2%), NH_4Cl (2%) гэсэн дараалалтай байна. POM-ийн хувьд онцгой өндөр агууламжтай байгаа бөгөөд энэ нь улирлын чанартай болохоос биш хөрснөөс үүдэлтэй тоосонцорын нөлөөлөл бага. Энд хэмжигдсэн POM-д өндөр агууламжийн VOC конденсацлагдсан хэлбэрээр оршиж байгаа нь улирлын чанартай онцлог уу үгүй юу гэдгийг VOC-ийн эх үүсвэрээр тодорхойлох шаардлагатай.

Хүснэгт 6. Голлох эх үүсвэрийн ангилалд хийсэн анализид тулгуурлан хоёрдогч үүсмэл нарийн ширхэглэлт тоосонцорыг тооцоолох аргачлал


① : Фильтрийн аргачлалаар PM2.5-ын массын агууламжийг тодорхойлох
② : PM2.5 дахь химийн элементийн найрлагын шинжилгээ
1. IMPROVE-A аргачлалаар нүүрстөрөгчийн нэгдэл, Органик карбон (OC) болон Элементийн карбон (EC)
2. Ионхроматограф (IC)-аар уусамтгай ионыг тодорхойлох: SO_4^{2-} , NO_3^- , NH_4^+ г.м
3. EDXFA-аар олон төрлийн элемент тодорхойлох: Na, Al, Si, S, Cl, K, Ca, Ti, Fe
③ : RCFM агууламжийн тооцоолол
$$\text{RCFM} = 4.125[\text{S}] + 1.4[\text{OC}] + [\text{EC}] + [\text{Soil}] + 1.4[\text{KNON}] + 2.5[\text{Na}] + 1.29[\text{NO}_3^-] + [\text{NH}_4\text{Cl}]$$
$$[\text{Soil}] = 2.32[\text{Al}] + 2.63[\text{Si}] + 1.72[\text{Ca}] + 1.67[\text{Fe}] + 2.05[\text{Ti}], \text{ гэхдээ } 10\% \text{-ийн чийг агуулж байх тохиолдолд}$$
$$[\text{KNON}] = [\text{K}] - R_0[\text{Fe}], \text{ гэхдээ } R_0 \text{ коэффициент нь том ширхэглэлт тоосонцор дахь } [\text{K}]/[\text{Fe}]$$
$$\text{POM} = C_1[\text{OC}], \text{ гэхдээ } C_1 \text{ коэффициент нь органик нэгдэл болох (POM) болон (OC)-ийн харьцаагаар байршлаас хамаарч } 1.4\text{-}2.2 \text{ байна.}$$




Зураг 3. Голлох эх үүсвэрийн ангилал дахь агууламж: Sample UB20140117C5F




Зураг 4. Голлох эх үүсвэрийн ангилал дахь агууламж: Sample UB20140118C5F



Зураг 5. Гол эх үүсвэрийн ангилал дахь агууламж: Sample UB20140120C7F



Зураг 6. Гол эх үүсвэрийн ангилал дахь агууламж: Sample UB20140121C7F



Зураг 7. Гол эх үүсвэрийн ангилал дахь агууламж: Sample UB20140123C2F

Монгол Улс

Агаарын бохирдлыг бууруулах газар (АББГ)

**Монгол Улс
Улаанбаатар хотын
Агаарын бохирдлын хяналтын
чадавхыг бэхжүүлэх төсөл
(2-р үе шат)**

**Техникийн хамтын ажиллагааны үр
дүнгийн тайлан 07
Эх үүсвэрийн инвентор боловсруулах,
шинэчлэх гарын авлага**

2017 он 3 сар

**Олон улсын хамтын ажиллагааны
ЖАЙКА байгууллага**

“Сүүри-Кэйкакү” ХК

ГАРЧИГ

1	Эх үүсвэрийн инвенторын үндсэн зарчим	1
1.1	Тооцооллын аргачлал	1
1.1.1	Ялгарлын коэффициент	1
1.1.2	Үйл ажиллагааны суурь өгөгдөл	1
1.2	Хамрагдах эх үүсвэр	1
1.3	Хамрагдах бохирдуулах бодис.....	2
1.4	Хамруулах хүрээ	2
1.5	Цаг хугацааны өөрчлөлт, орон зайн тархалт.....	2
1.5.1	Цаг хугацааны өөрчлөлт.....	2
1.5.2	Орон зайн тархалт	2
2	ДЦС-ын ялгарлын инвентор.....	3
2.1	Ялгарлын инвентор боловсруулах, шинэчлэх аргачлал	3
2.1.1	Инвенторт ашиглах өгөгдлийг цуглуулах, боловсруулах	3
2.1.2	Ялгарлын коэффициент (Я/К) -ийг тооцоолоход шаардлагатай мэдээллийг цуглуулах	4
2.1.3	Инвентор боловсруулах ба шинэчлэх	5
2.2	Инвенторын файлыг Access уруу оруулах	6
2.3	Цэгэн эх үүсвэрийн өгөгдөлд газарзүйн координатыг оруулах, координатын системийг өөрчлөх	9
2.4	Ялгарлын хэмжээний тархалтын зураг боловсруулах	18
3	УХЗ-ны ялгарлын инвентор боловсруулах, шинэчлэх аргачлал.....	25
3.1	Ялгарлын инвентор боловсруулах, шинэчлэх аргачлал	25
3.1.1	Зуухны мэдээлэл цуглуулах, өгөгдлийг боловсруулах.....	25
3.1.2	Я/К-ийн тооцоололд шаардлагатай мэдээллийг цуглуулах	26
3.1.3	Инвентор боловсруулах ба шинэчлэх	28
3.2	Инвенторын файлыг Access уруу оруулах	30
3.3	Цэгэн эх үүсвэрийн өгөгдөлд газарзүйн координатыг оруулах, координатын системийг өөрчлөх арга	32
3.4	Ялгарлын хэмжээний тархалтын зураг боловсруулах	41
4	Бага оврын УХЗ-ны ялгарлын инвентор боловсруулах, шинэчлэх аргачлал.....	48
4.1	Ялгарлын инвентор боловсруулах, шинэчлэх аргачлал	48
4.1.1	100 кВтг хүртэлх хүчин чадал бүхий УХЗ-ны бүртгэлийн мэдээлэл цуглуулах, боловсруулах	48
4.1.1.1	2009 оны Дэлхийн банкны судалгааны дүнг ашиглах аргачлал.....	48
4.1.1.2	2014 оны суурин эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн мэдээг ашиглах нь ...	49
4.1.2	Я/К-ийн тооцоололд шаардлагатай мэдээллийг цуглуулах	49

4.1.3	Инвентор боловсруулах ба шинэчлэх	50
4.2	Инвентор файлыг Access уруу оруулах	52
4.3	Хороодын ялгарлын хэмжээг гридээр тооцоолох тухай	54
4.4	Ялгарлын хэмжээний тархалтын зураг боловсруулах	59
5	Гэрийн зуухны ялгарлын инвентор боловсруулах, шинэчлэх аргачлал	67
5.1	Ялгарлын инвентор боловсруулах, шинэчлэх аргачлал	67
5.1.1	Гэрийн зуухны мэдээллийг цуглуулах, боловсруулах	67
5.1.1.1	Нийслэлийн Статистикийн мэдээг ашиглах нь	67
5.1.1.2	2014 онд хэрэгжсэн суурин эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн өгөгдөл, мэдээллийг ашиглах нь	68
5.1.2	Я/К-ийг тооцоолоход шаардлагатай мэдээллийг цуглуулах	68
5.1.3	Инвентор боловсруулах ба шинэчлэх	68
5.2	Инвентор файлыг Access уруу оруулах	72
5.3	Хороодын ялгарлын хэмжээг гридээр тооцоолох нь	74
5.4	Ялгарлын хэмжээний тархалтын зураг боловсруулах	78
6	Хөдөлгөөнт эх үүсвэрийн инвентор	84
6.1	Ялгарлын инвентор боловсруулах, шинэчлэх аргачлал	84
6.1.1	Үйл ажиллагааны суурь өгөгдлийг цуглуулах, нэгтгэж боловсруулах	84
6.1.2	Я/К-ийг тооцоолоход шаардлагатай өгөгдлийг цуглуулах, нэгтгэж боловсруулах	85
6.1.2.1	Автомашинь төрлөөр Я/К-ийг тооцооход шаардлагатай мэдээлэл	85
6.1.2.2	Автозамын тоосны Я/К-ийг боловсруулахад шаардлагатай мэдээлэл	86
6.1.3	Инвентор боловсруулах, шинэчлэх	87
6.1.3.1	Хөдөлгөөний эрчмийн мэдээллийг шинэчлэх	87
6.1.3.2	Автозамын сүлжээг шинэчлэх	89
6.1.3.3	Автомашинь оношлогоо, бүртгэлийн өгөгдлийг шинэчлэх	95
6.1.3.4	Японы хаягдал утааны ялгарлын стандарт ангиллыг ашиглах	99
6.1.3.5	Монголын нөхцөл байдлыг тусгасан коэффициентийг нэмж оруулах	106
6.1.3.6	Тээврийн хэрэгслийн төрлөөр жилийн тухайн замын нийт зорчилтыг тодорхойлох	114
6.1.3.7	Тээврийн хэрэгслийн ангиллаар ялгарлын стандартанд хамрагдах хувь	115
6.1.3.8	Тээврийн хэрэгслийн ангиллаар Я/К-ийг тооцоолох	127
6.1.3.9	Автозамаар хөдөлгөөнд оролцох тээврийн хэрэгслийн хаягдал утааны ялгарлын хэмжээний тооцоолол	135
6.1.3.10	Нарийн туслах замаар хөдөлгөөнд оролцох автомашинь хаягдал утааны ялгарлын тооцоолол	139
6.1.3.11	Автозамын тоосны Я/К	142

6.1.3.12	Автозамын хөдөлгөөнөөс үүдэлтэй тоосны ялгарлын хэмжээг тооцоолох.....	142
6.1.3.13	Нарийн туслах (засмал) замын хөдөлгөөнөөс үүдэлтэй тоосны ялгарлыг тооцоолох	147
6.1.3.14	Нарийн туслах (шороон) замын хөдөлгөөнөөс үүдэлтэй тоосны ялгарлыг тооцоолох	150
6.2	Хөдөлгөөнт эх үүсвэрийн инвенторыг тархалтын загварчлалын оролтын өгөгдлийн хэлбэрт хувиргах аргачлал.....	152
6.3	Ялгарлын хэмжээний тархалтын зураг боловсруулах	159
7	Бусад эх үүсвэрийн инвентор (ДЦС-ын үнсэн сангийн хийсэлт)	166
7.1	Ялгарлын инвентор боловсруулах, шинэчлэх аргачлал.....	166
7.1.1	Үйл ажиллагааны суурь өгөгдөл, мэдээллийг цуглуулах, нэгтгэх.....	166
7.1.2	Я/К-ийг тооцоолоход шаардлагатай мэдээллийг цуглуулах.....	167
7.1.3	Инвентор боловсруулах ба шинэчлэх	167
7.2	Инвентор файлыг Access уруу оруулах.....	169
7.3	Үнсэн сангийн хийсэлтийн хэмжээг гридээр тооцоолох тухай.....	170
7.4	Ялгарлын хэмжээний тархалтын зураг боловсруулах	172

1 Эх үүсвэрийн инвенторын үндсэн зарчим

1.1 Тооцооллын аргачлал

Ялгарлын хэмжээг ялгарлын эх үүсвэрийн ангилал тус бүрээр дараах үндсэн томъёог ашиглан тооцоолдог. Тооцооллын дэлгэрэнгүй аргачлалыг эх үүсвэр тус бүрээр тайлбарлах болно.

$$\text{Ялгарлын хэмжээ} = \text{Ялгарлын коэффициент} \times \text{Үйл ажиллагааны суурь өгөгдөл}$$

Жишээ:

• Түлшний хүхрийн агууламж, хаягдал үнсэнд агуулагдах хүхрийг бууруулах технологийг ашиглан ялгарлын хэмжээг

багасгах зэрэгт тулгуурлан тооцоолсон түлшний зарцуулалтанд оногдох SO_x ялгарлын хэмжээ (Шаталтаас үүдэлтэй SO_x ялгарал)

• Туулах зайнд оногдох NO_x-ын ялгарал (Автомашинны хаягдал утаа)

• Түлшний зарцуулалт (Шаталтын явц)
• Автомашинны туулах зай (Автомашинны хаягдал утаа)

1.1.1 Ялгарлын коэффициент

Ялгарлын коэффициент нь нэгж үйл ажиллагааны суурь өгөгдөл (activity data)-д оногдох бохирдуулах бодисын дундаж ялгарлын хэмжээ юм.

Тус гарын авлагад УБ хотын хэмжилтийн өгөгдөлд тулгуурлан тодорхойлсон ялгарлын коэффициент (Я/К)-ийг ашиглах нь зүйтэй хэдий ч хэмжилтийн өгөгдөлд тулгуурласан Я/К байхгүй тохиолдолд Европ, Америк, Япон зэрэг улсуудын гарын авлагын Я/К-ийг ашиглах шаардлагатай болдог. Тухайлбал, “Ялгарлын инвентор боловсруулах гарын авлага”¹, GAP Forum Manual², EMEP/EEA Guidebook³, AP-42⁴, COPERT⁵ гэх мэт.

1.1.2 Үйл ажиллагааны суурь өгөгдөл

Үйл ажиллагааны суурь өгөгдөл нь ялгаруулж буй үйл ажиллагааны хэмжээг илэрхийлдэг бөгөөд шаардлагатай суурь өгөгдөлд ихэвчлэн статистик мэдээ, судалгааны дүн, материал зэргийг ашиглах боломжтой.

Тус гарын авлагад үйл ажиллагааны суурь өгөгдөл болгож УБ хотын хэмжээнд хийгдсэн судалгааны өгөгдөл, статистикийн мэдээллийг ашигласан.

1.2 Хамрагдах эх үүсвэр

Эх үүсвэрт ДЦС, УХЗ, Бага оврын УХЗ болон гэрийн зуухны түлшний шаталтаас үүдэлтэй ялгарал, автомашинны хаягдал утаа, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэлтэй автозамын тоос шороо, ДЦС-ын үнсэн сангийн хийсэлт зэргийг хамруулсан.

¹ http://www.acap.asia/publication/pdf/em_inventory/em_guideline.pdf

² <https://www.sei-international.org/gapforum/emissions-manual.php>

³ <https://www.eea.europa.eu/publications/emep-eea-guidebook-2016>

⁴ <https://www.epa.gov/air-emissions-factors-and-quantification/ap-42-compilation-air-emission-factors>

⁵ <http://emisias.com/products/copert>

1.3 Хамрагдах бохирдуулах бодис

Бохирдуулах бодист SO₂, NO_x, TSP, PM₁₀, CO-ыг хамруулсан.

1.4 Хамруулах хүрээ

УБ хотын төвийн 6 дүүрэг (Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй)-ийг хамруулах бөгөөд эдгээр дүүрэг нь олон хүн амтай, түлшний зарцуулалт ихтэй тул агаар бохирдуулах бодисын ялгарал ихтэй байдаг.

1.5 Цаг хугацааны өөрчлөлт, орон зайн тархалт

1.5.1 Цаг хугацааны өөрчлөлт

Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний судалгаа, загварчлалын моделийн оролтын өгөгдөл зэргийг боловсруулахын тулд ялгарлын хэмжээний цаг хугацааны өөрчлөлтийг тохируулах шаардлагатай байдаг. Эх үүсвэрийн ялгарлын бодит байдалд нийцүүлэн улирлаар, сараар, долоо хоногоор, өдрөөр, өдрийн цаг/шөнө зэргээр ялгарлын цаг хугацааг тохируулж зааснаар цаг хугацааны өөрчлөлтөөс хамааруулж ялгарлыг тооцоолдог. Мөн санал асуулга, биечилж хийсэн судалгаа, хөдөлгөөний эрчмийн судалгаа зэрэг эх үүсвэрийн мэдээллийг тус бүрт нь цуглуулж, тухайн эх үүсвэрийн ажиллагааны хувилбар, цаг тутмын хөдөлгөөний эрчим зэргээр цаг хугацааны өөрчлөлтийг илүү дэлгэрэнгүй тодорхойлох боломжтой.

1.5.2 Орон зайн тархалт

Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний судалгаа, загварчлалын моделийн оролтын өгөгдөл зэргийг боловсруулахдаа нийт ялгарлын хэмжээнээс илүү нарийвчилж орон зайн тархалтаар ялгарлын хэмжээг хувааж тодорхойлох шаардлагатай байдаг. Ялангуяа талбайн эх үүсвэрийн хувьд үүсэх магадлалтай талбайн хүрээг тогтоосноор ялгарлын тархалтыг илүү нарийвчилж тооцоолох боломжтой бөгөөд ингэснээр тархалтын загварчлалын моделийн нарийвчлал сайжирдаг.

Нөгөө талаар ДЦС, УХЗ зэрэг биечилсэн судалгаа, санал асуулгаар эх үүсвэр тус бүрээр мэдээллийг цуглуулах боломжтой эх үүсвэрийн хувьд цэгэн эх үүсвэрээр инвенторыг боловсруулах шаардлагатай байдаг. Мөн автомашины хаягдал утааны ялгарлыг автозамын сүлжээний өгөгдөл, мэдээнд тулгуурлан хөдөлгөөний эрчмийн судалгаа зэрэг эх үүсвэрийн мэдээллийг цуглуулж, шугаман эх үүсвэрээр инвенторыг боловсруулна.

2 ДЦС-ын ялгарлын инвентор

2.1 Ялгарлын инвентор боловсруулах, шинэчлэх аргачлал


Яндан тус бүрээр ялгарлын хэмжээг тооцоолно. Харин нэг багц яндантай тохиолдолд тухайн зуух тус бүрээр ялгарлын хэмжээг тооцоолж, тэдгээрийн нийлбэрийг тухайн яндангийн ялгарлын хэмжээ гэж үзнэ. ДЦС-ын ялгарлын хэмжээг тооцоолох ажлын дарааллыг Зураг 2-1-д үзүүлэв. Дараах томъёог ашиглан ялгарлын хэмжээг тооцоолно. Цаг хугацааны тархалтын хувьд зуух тус бүрээр, сараар гаргасан нүүрсний зарцуулалтыг ашиглан сар тус бүрээр ажиллагааны хувилбарыг тооцоолно. Илүү нарийвчилсан байдлаар ажиллагааны хувилбарыг тодорхойлох бол SEMS буюу утааны хийн тасралтгүй хэмжигчийн хэмжилтийн дүнг ашиглан цагийн ангиллаар ажиллагааны хувилбарыг тооцоолох аргачлал байдаг.

$$E_i = AD_i \times EF_i$$

E_i : Яндан i -ын ялгарлын хэмжээ (тонн/жил)

AD_i : Яндан i -тай холбогдсон зуухны жилийн нүүрсний зарцуулалт (тонн/жил)

EF_i : Яндан i -ын ялгарлын коэффициент (кг/тонн түлш)



Зураг 2-1 ДЦС-ын ялгарлын хэмжээг тооцоолох ажлын дараалал

2.1.1 Инвенторт ашиглах өгөгдлийг цуглуулах, боловсруулах

ДЦС-уудад албан бичгээр тухайн оны нүүрс зарцуулалтын мэдээллийг авах хүсэлт гаргах бөгөөд дараах байдлаар авах мэдээллийн агуулгыг тодорхой заасан загварын хамт явуулж, цахим хэлбэрээр мэдээллийг авах.

- 1) Яндангийн өндөр, амсарын диаметр
- 2) Яндангийн амсарын түвшингийн утааны хийн температур, хурд (эсвэл зарцуулалт)

Эх үүсвэрийн инвентор боловсруулах, шинэчлэх гарын авлага

- 3) Зуух ашиглалтын байдал (Сар тус бүрээр нүүрс зарцуулалтын хэмжээ, зуухны ашигт үйлийн коэффициент)
- 4) Нүүрсний шинж төлөв (уурхайн нэр, илчлэг, хүхэр болон үнсний агууламж)
- 5) Бохирдуулах бодис тус бүрээр утааны хийн агууламж, инвентор боловсруулахад шаардлагатай бусад мэдээлэл

The screenshot shows an Excel spreadsheet titled 'Inventory2015_Allala - Microsoft Excel'. The main data table is titled 'Мэдээлэл авах газар: Цахилгаан станц тус бүрээс авна.' and contains a detailed inventory of power plants. The columns include: Станц (Plant), Диаметр (Diameter), Өндөр (Height), Улааны температур (Ambient temperature), Утааны хурд (Ash rate), Уртгар (Length), Өргөрөг (Width), Зуухны дугаар (Furnace number), 1-12 (Fuel analysis parameters), Нийт (Total), АУХ % (Efficiency %), Инвентор ооног (Inventory count), Нүүрсний төрөл (Coal type), Нүүрсний зэвцүүлэлт (Ash content), Дотоон үйлдвэрлэл (Internal production), Үнэмт (Value), and Үнэмийн нэгж (Value unit). The table lists data for Power Plant 2, 3-1, 3-2, and 4, with multiple rows for each plant representing different furnace units.

ДЦС-уудын холбоо барих хаягыг доор үзүүлэв. Хариуцсан ажилтан өөрчлөгдсөн тохиолдолд хүснэгтийг шинэчилж байх.

ДЦС	Хариуцагч ажилтан	Харьяалах алба, хэлтэс	Холбоо барих утас
ДЦС-2			
ДЦС-3			
ДЦС-4			
Амгалан ДС			

2.1.2 Ялгарлын коэффициент (Я/К) -ийг тооцоолоход шаардлагатай мэдээллийг цуглуулах

2010 он ~ 2011 онд ЖАЙКА төслийн хүрээнд ДЦС-уудад утааны хийн хэмжилт хийгдсэн бөгөөд хэмжилтээр Я/К-ийг тооцоолж гаргасан. Эдгээрийг ДЦС-ын зуухны систем тус бүрээр дараах утгыг гаргаж тодорхойлсон.

ДЦС	SO2	NOx	TSP	PM10	CO	Ашигласан нүүрс
ДЦС-2 (*1)	3.31	0.97	23.37	15.19	41.35	Багануур
ДЦС-3-1	7.35	6.91	10.47	6.81	1.13	Багануур
ДЦС-3-2	1.64	0.88	5.13	3.33	0.23	Багануур
ДЦС 4 (*2)	2.19	3.87	2.87	1.87	0.03	Багануур

Эх сурвалж: НАЧА&ЖАЙКА, 2013

*1: 2011. 01~02 сард 35 т/ц зууханд нэг удаа, 75 т/ц зууханд 3 удаа хийгдсэн хэмжилтийн дундаж утга.

*2: 2010.09 сарын 3 удаагийн утааны хийн хэмжилтэнд Багануурын нүүрсийг ашигласан.

Я/К-ийг 2010 ~ 2011 оны утааны хийн хэмжилтэнд тулгуурлан тооцоолсоноос хойш тухайн байгууламж, тоног төхөөрөмж нь шинэчлэгдэж сайжирсан газрууд байгаа учраас зуухны утааны хийн хэмжилтийг тогтмол хугацаанд хэрэгжүүлэх, хэмжилтийн дүнг хамтран эзэмших талаар санал гаргах зүйтэй юм. Мөн утааны хийн хэмжилтийн дүн нь зуухны ачааллын байдлаас хамаарч ялгаатай гардаг учраас хэмжилтийн давтамж, түлшний найрлага дахь хүхрийн агууламжийн шинжилгээг олон удаа хийж, Я/К-ийн нарийвчлалыг сайжруулах нь зүйтэй юм.

2.1.3 Инвентор боловсруулах ба шинэчлэх

ДЦС-ын инвенторыг боловсруулах, шинэчлэхэд PowerPlantEmissionInventory.xls-ыг ашиглах. Шинэ ДЦС болон томоохон хүчин чадал бүхий дулаан түгээх байгууламж, станц шинээр байгуулагдсан үед тэдгээрийн мэдээллийг нэмж оруулах.

Нүүрсний зарцуулалтын мэдээг яндан тус бүрээр нэгтгэн тооцоолж, [FuelConsumption_TPY] баганыг шинэчлэх.

